



ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 01 сарын 06 өдөр

Дугаар 03

Өмнөдэлгэр сум

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг
зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит Дөрөвдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2.Зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэгдсэнтэй холбогдуулан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/23 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.

3.Зөвлөл нь ажлын төлөвлөгөө боловсруулан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэн ажиллаж биелэлтийг бүтэн жилээр иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж холбогдох арга хэмжээ авч ажиллахыг зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нарт, зөвлөлийн ажилд идэвх санаачилгатай оролцохыг гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ПҮРЭВДОРЖ

Өмнөдэлгэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2025 оны 01 дүгээр сарын 04 ны
өдрийн Дөрөвдүгээр хуралдааны 03
дугаар тогтоолын хавсралт



Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах
салбар зөвлөлийн бүрэлдэхүүн

Зөвлөлийн дарга:	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга
Нарийн бичгийн дарга:	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны мэргэжилтэн
Гишүүд:	Хүүхэд хамгааллын хамтарсан багийн нарийн бичгийн дарга Хэсгийн төлөөлөгч Экологийн цагдаа Ерөнхий боловсролын сургуулийн захирал Соёлын төвийн эрхлэгч Цэцэрлэгийн эрхлэгч Эрүүл мэндийн төвийн дарга Байгаль Орчны Хяналтын Улсын Байцаагч Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн Хурх тосгоны захирагч 1-р багийн Засаг дарга 2-р багийн Засаг дарга 3-р багийн Засаг дарга 4-р багийн Засаг дарга 5-р багийн Засаг дарга 6-р багийн Засаг дарга Цаг уурын өртөөний дарга Ахмадын хорооны тэргүүн Хангалын жолоо Төрийн бус байгууллагын тэргүүн